



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 5 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Төрийн өмчийн оролцоотой хуулийн
этгээд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой, “Дорнын төмөр зам” ХХК-тай хамтарсан “Зүүнбаян төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

2. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн нийт хувьцааны төрд ногдох хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д эзэмшүүлэхээр тогтсугай.

3. “Монголын төмөр зам” ТӨХК, “Дорнын төмөр зам” ХХК-иас Сайншанд-Тавантолгой чиглэлийн төмөр замын төслийн бэлтгэл ажилд зориулан зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувь хөрөнгөд оруулж тооцох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

4. “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг байгуулах болон энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн аудит хийлгэхэд шаардагдах зардлыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн болон зорилтот түвшний үзүүлэлтийг тодотгох замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Р.Мэргэн)-д тус тус зөвшөөрсүгэй.

5. “Зүүнбаян төмөр зам” ХХК-тай Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр барьж байгуулах хэлэлцээ хийж, гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Ж.БАТ-ЭРДЭНЭ